

---

# ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ДҮГНЭЛТ, САНАЛ

---

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

Д.ДАВААСАМБУУ

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

Г.АЛТАНЗАЯА

Б.БАЯРДАВАА

Э.БЯМБАЖАВ

Ё.МӨНХБААТАР

Л.ОТГОНТУЯА

Д.СУВДАА

А.ЭНХЖИН

2021 оны 10 дугаар сарын 22  
Улаанбаатар хот

## АГУУЛГА

<b>НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ХУРААНГУЙ</b> .....	2
Дотоод орчин: .....	2
Гадаад орчин: .....	2
<b>ХОЁР. ТӨСВИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫГ САЙЖРУУЛАН ТОДОРХОЙЛОХОД ЗАЙЛШГҮЙ АНХААРАХ ЗҮЙЛ</b> .....	3
<b>ГУРАВ: ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ</b> .....	8
Төсвийн орлогын талаар: .....	9
Төсвийн зарлагын талаар: .....	12
Хөрөнгө оруулалтын талаар: .....	13
Төсөв хоорондын харилцааны талаар: .....	15
Нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт: .....	16
<b>Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд дараах саналуудыг тусгуулахаар санал болгож байна.</b> ....	18
<b>ХАВСРАЛТУУД</b> .....	20
Хавсралт хүснэгт №1а: МОНГОЛ УЛСЫН ГАДААД НИЙТ ӨР (ангилалаар, оны эцэст) .....	20
Хавсралт хүснэгт №1b: ХУВИЙН ХЭВШЛИЙН ГАДААД ӨР (оны эцэст, уул уурхай болон бусад) .....	20
Хавсралт хүснэгт №1с: МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД БОНДЫН ӨР(бондны төрлөөр, оны үлдэгдэлээр) .....	20
Хавсралт хүснэгт №2: ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ(оноор) .....	21
Хавсралт хүснэгт №3: МОНГОЛ УЛСАД ОРСОН ГШХО-ЫН ҮЛДЭГДЭЛ (Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, оны үлдэгдэлээр) .....	22
Хавсралт хүснэгт №4а: ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН (орлогын аргаар, оны үнээр).....	22
Хавсралт хүснэгт №4б: ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН (орлогын аргаар, орлогын татвараар, оны үнээр).....	23
Хавсралт хүснэгт №5: МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ (2014 оноос 2022 он).....	23
Хавсралт хүснэгт №6: МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ ЭКСПОРТ (Нийт болон Гашуунсухайт, тоон хэмжээгжээр, үнийн дүнгээр) .....	24
Хавсралт хүснэгт №7: МОНГОЛ УЛСЫН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ИМПОРТ (тоон хэмжээгжээр, үнийн дүнгээр).....	24

## МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ДҮГНЭЛТ, САНАЛ

### НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ХУРААНГУЙ

**Дотоод орчин:** Монгол Улсын суурь салбар болсон мал аж ахуй, газар тариалангийн өнөөгийн байдал, дотоод зах зээл, хүнсний хангамжийг хэвийн байлгах нөхцөлийг бүрдүүлж байна. Төрөөс цар тахлын үед иргэд, аж ахуйн нэгжийн худалдан авах чадварыг хадгалах, ажлын байр, зээлийн бууралтыг сааруулах, хадгалах, улмаар нэмэгдүүлэх, эрүүл мэнд, нийгмийн халамжаас бусад төсвийн зардалд хэмнэлтийн горимыг тогтоох зэрэгт чиглэсэн олон арга хэмжээг төсвийн хүрээнд болон түүний гадуур авч хэрэгжүүлж байна. Нөгөө талаас иргэд, аж ахуйн нэгжүүд ч хэрэглээндээ хариуцлагатай хандаж, үндсэн хэрэгцээ, дотоодын хангалтыг илүүтэй үзэх болсон нь сайшаалтай.

Дэлхий дахинаа сүүлийн үед таваарын бүтээгдэхүүний үнэ өсөх хандлагатай, тухайлбал, 2021 он гарсаар зэс, төмрийн хүдрийн үнэ өссөн бол коксжих нүүрсний үнэ тогтвортой байгаа нь Монгол Улсын эдийн засаг сэргэх, төсвийн орлогын төлөвлөгөө биелэх суурь боломжийг хангаж байна.

Гадаад валют, түүний дотор ам.доллартой харьцах төгрөгийн ханш жил гаруй хугацаанд тогтвортой буюу 2,850 орчим төгрөг байна. Газрын тосны үнийн өсөлт, улс хоорондын худалдааны тасалдал, зарим барааны нийлүүлэлтэд үүсэж буй хүндрэл зэргээс үүсэлтэйгээр инфляцын дарамт нэмэгдэх эрсдэл байна. Үүний зэрэгцээ дотоод, гадаад өрийн дарамт их байгаа юм. Засгийн газраас өнөөг хүртэл төсвийн алдагдлыг бондын зээллэгээр санхүүжүүлэхгүй байх чиг хандлага баримталж байгааг дэмжиж байна.

Манай орны эдийн засагт учирч буй хамгийн том дарамт бол улсын өр юм. Энэ ч учраас Сангийн яам, Монголбанк 2022 онд төлөгдөх 1 тэрбум ам.долларын үнийн дүнтэй, 5.125 хувийн хүүтэй Чингис бондын үлдэгдэл 799 сая ам.долларыг бүрэн хэмжээгээр, 2023 онд төлөгдөх 5.625 хувийн хүүтэй 800 сая ам.долларын үнийн дүнтэй Гэрэгэ бондоос 200 сая ам.долларыг 1 тэрбум ам.долларын “Зуун-Сенчюри” бонд (6 жилийн хугацаатай 3.5 хувийн хүүтэй 500.0 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай 4.45 хувийн хүүтэй 500 сая ам.доллар)-ын зээллэгээр солих ажлыг зохион байгуулж, өрийн дарамтыг хойшлуулсан байна. Дэлхий дахинд бондын хүү нэмэгдэх нөхцөл үүсэж болохыг сүүлийн үед мэдээлэх болсон нь цаг хожсон бөгөөд хүүний хэмжээг 1.5 гаруй нэгж хувиар буулгасан байна.

Дээрх нааштай алхам, тааламжтай орчны үр дүнд эдийн засгийн уналт 2021 онд зогсож, 4.1 хувийн өсөлт (өмнөх оны 4.6 хувийн уналтыг бүрэн нөхөж чадаагүй) гарах тооцоо гарч, мөнгөний нийлүүлэлт оны эхний 9 сард 27 их наяд төгрөгт хүрч, 20.4 хувиар өсөж, нэгдсэн төсвийн суурь алдагдал 190.2 тэрбум төгрөг болсон статистик байна. Сүүлийн жил гаруй хугацаанд зээл, хадгаламжийн дундаж хүү нэлээд буурлаа. Зээлийн хүүгийн нэгдсэн бодлогоо цаашид барьж чадвал хүү аажимдаа тогтворжих боломжтой. Он дуустал хилийн гарцуудыг нээлттэй байлгах, экспорт, импортод тасалдал гаргахгүй байх нь нийт эдийн засаг, ялангуяа төсөвт чухал нөлөөтэй байх болно.

**Гадаад орчин:** Олон улсын валютын сангаас 2021 оны 10 дугаар сард Дэлхийн эдийн засгийн өсөлтийн талаарх төсөөллийг багахан бууруулсан тоймыг гаргалаа. Чухал нөлөөтэй гэсэн орнуудын талаарх төсөөллийг доорх хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын тойм (өөрчлөлтийн хувь)

	2019	2020	Төсөөлөл	
			2021	2022
<b>Дэлхийн өсөлт</b>	<b>2.8</b>	<b>-3.1</b>	<b>5.9</b>	<b>4.9</b>
Хөгжингүй эдийн засаг	1.7	-4.5	5.2	4.5
<i>АНУ</i>	2.3	-3.4	6.0	5.2
<i>Европын холбоо</i>	1.5	-6.3	5.0	4.3
<i>Япон</i>	0.0	-4.6	2.4	3.2
<i>ИБУИИХУ</i>	1.4	-9.8	6.8	5.0
Хөгжиж буй эдийн засаг	3.7	-2.1	6.4	5.1
<i>Хятад</i>	6.0	2.3	8.0	5.6
<i>Оросын Холбооны улс</i>	2.0	-3.0	4.7	2.9

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн тайлан, ОУВС

Манай орны эдийн засгийн амьдралыг голлон шийддэг таваарын бүтээгдэхүүний үнэ, эрэлт, нийлүүлэлт дэлхийн хэмжээний эдийн засагтай орнуудын нөхцөл байдлаас ихээхэн хамаардаг. Дээр дурдсан эдийн засгийн тоймд ОУВС газрын тосны үнийг 59 хувиар, тосны бус таваарын бүтээгдэхүүний үнийг 26 хувиар 2021 онд өсөхөөр тооцсон бол 2022 онд газрын тос 1.9 хувиар, тосны бус таваарын бүтээгдэхүүний үнэ 0.9 хувиар тус тус бууралттай байх төсөөлөл гаргажээ.

Сүүлийн үед Хятадын эдийн засгийн өсөлт саарч, жилийн дүнгээр 6 хувиас хэтрэхгүй байх магадлал нэмэгдэж байна. Гэхдээ сорилт их байна. БНХАУ-д гаргах нүүрсний экспортыг баталгаажуулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх явдал чухал юм. Сүүлийн үед Ковид-19 цар тахал Өвөр Монгол, нийт Хятадад эргэн тархах эрсдэл байна.

Бас нэг эрсдэл бол газрын тосны импорт болоод байна. Дэлхийн зах зээл дээр газрын тосны цар тахлын эхний үеийн хатуу хөл хорионы үеэс бараг 2 гаруй дахин нэмэгдэж, өдгөө баррель нь 84 ам.доллар болжээ. АНУ-ын хөрөнгө оруулалтын Голдмэн Саксын тооцоогоор оны эцэст 90 ам.доллар давж, ОХУ-ын Ерөнхийлөгч Путинийн хэлсэнчлэн 100 ам.долларт хүрэх эрсдэл байсаар байна. Эрэлт өдгөө өвөл цагт ихдэж, үйлдвэрлэлийн өсөлт удаан байна гэсэн мэдээ тархаад байгаа. Ингэвэл манай улсаас нефть бүтээгдэхүүний импортод төлөх мөнгө тэрбум хүртэл ам.доллараар өсөх эрсдэлтэй.

Үүний зэрэгцээ баруун европ, хятад зэрэг орнуудын эрчим хүчний доголдол, АНУ-ын Засгийн газрын өр, төсвийн хүндрэл, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн хямрал энэ чиглэлийн зарим компанийн бондын өрийн эргэн төлөлтийн саатал зэрэг хүндрэл олон улсын хэмжээний сорилт үүсгэж байна. Эдгээрээс сургамж авч төсөв, санхүүгийн бодлого, чиглэлээ тодорхойлох хэрэгтэй болж байна.

Олон улсын зарим байгууллагууд, Монголбанк зэрэг байгууллага манай орны эдийн засгийн өсөлтийг илүү өөдрөг төсөөлсөнд Засгийн газар болгоомжтой хандаж, 2022 оны эдийн засгийн өсөлтийг 5 орчим хувь байхаар төсөөлсөн нь үндэслэлтэй гэж үзэж байна.


**ХОЁР. ТӨСВИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫГ САЙЖРУУЛАН  
ТОДОРХОЙЛОХОД ЗАЙЛШГҮЙ АНХААРАХ ЗҮЙЛ**

Хуулийн нийцэл, мөрдөлтийн асуудлыг хөндөн тавих шаардлага үүсэж байна. УИХ-аас хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах Үндсэн хуулиар олгогдсон онцгой эрхийн хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай 2010 оны хуульд 10 гаруй удаа Засгийн газрын хүсэлтийн дагуу өөрчлөлт оруулаад байна. Ингэхдээ төсвийн тусгай шаардлага буюу төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувиас хэтрүүлэхгүй, эсвэл ашигтай байлгах, Засгийн газрын өрийг мөн ДНБ-ий 40 хувиас хэтрүүлэхгүй байх тухай

шалгуурыг өөрчилдөг буруу хандлага тогтлоо. Үүнийг залруулж зогсоох шаардлагатай болохыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, түүний гишүүдийн зүгээс онцгойлон анхааруулж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд төсвийн тусгай шаардлагыг 4 жил тутам хянан үзэж байх, эдийн засгийн өсөлт хасах болсон, томоохон гамшиг буюу өнөөгийн КОВИД-19 цар тахлын хэмжээний зардалтай дүйцэхүйц гамшиг гарвал дээрх 2 төсвийн тусгай шалгуурыг мөрдөхийг түр түдгэлзүүлэх хуулийн заалттай. Гэтэл энэхүү шалгуурыг өөрчилсөөр байгаа нь Үндсэн хуулийн нэгдүгээр зүйл дэх “хууль дээдлэх” зарчимд нийцэж буй эсэх, улмаар төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн хэмжээ Засгийн газрын өрийн эрсдэлийн судалгаагаар анхаарлын дээд түвшинд хүрчээ гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Энэ бүхэн цаашид Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд тусгагдсан төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилтод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах тухай асуудлыг хөндөн ярихад хүргэж мэдэхээр байна. Төсвийн алдагдал ДНБ-нд харьцуулснаар хэрхэн өөрчлөгдсөнийг дараах зургаас харж болно.

**Зураг 1. ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын динамик (хувиар)**



Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн баримт бичиг

Төсөв, төлбөрийн тэнцлийн алдагдал эцсийн дүндээ улс орны өрийн хэмжээг нэмэгдүүлж байна. Хавсралт (хүснэгт №1)-д Монгол Улсын нийт гадаад өрийг эдийн засгийн зарим ангиллаар гаргаж үзүүлэв. Засгийн газар өрийн эрсдэлийн шинжилгээ хийж, анхаарах асуудлуудыг тодорхой гаргажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны төсвийн баримт бичигт дурдсанаар “Засгийн газрын өр анхааруулах дээд түвшин буюу 45 хувиас давж, 93 хувь болсон байна” гэжээ. Өр нэмэгдэж буй гол шалтгаан бол төсвөөс гадна Монгол Улсын төлбөрийн урсгал тэнцэл олон жил алдагдалтай гарч, улмаар төсөвт ихээхэн ачаалал нэмэх хандлагатай болсонтой холбоотой. Урсгал данс ийнхүү алдагдалтай байгаа нь гадаадаас авах санхүүжилтийн хэрэгцээг үүсгэж байна.

Анхааруулах дээд түвшингээс давсан өөр нэг үзүүлэлт бол гадаад санхүүжилтийн хэрэгцээ ажээ. 2020 оны урсгал тэнцэл дэх улсын болон хувийн секторын гадаад өрийн үйлчилгээний төлбөрийн нийлбэр нь ДНБ-ий 19 хувь байгаа нь анхааруулах дээд түвшин 15 хувиас давжээ гэдгийг Сангийн яамнаас мөн тооцон гаргасан байна. Азийн хөгжлийн банкны 2021 оны Азийн орнуудын хөгжлийн төлөвийн тухай судалгаанд Монгол Улсын өрийн үйлчилгээний төлбөр нь тус улсын нийт бараа үйлчилгээний орлогын 42.5 хувь (2016), 48.6 хувь (2017), 50.1 хувь

(2018), 40.8 хувь (2019), 44.5 хувь (2020)-ийг эзэлж буйг тэмдэглэжээ (Asian development outlook 2021, ADB).

Урсгал төлбөрийн тэнцлийн динамикаас үзэхэд 2008 оноос хойш жил бүр алдагдалтай гарч байсны дотор уул уурхайн бүтээн байгуулалт ид өрнөсөн 2011-2013 онд урсгал тэнцлийн алдагдал 4-5 тэрбум ам.доллар хүрч байжээ. Үүнийг хавсралтын хүснэгт №2-оос дэлгэрүүлэн үзнэ үү.

Энэ бол манай улсад үйлдвэрлэлийн бааз, мэргэжлийн ажиллах хүчний нөөц байхгүй, гадаадаас авсан зээл, хөрөнгө оруулалт эргээд импортын болон гадаадын мэргэжилтэн, ажилчдын төлбөрт шууд зориулагдаж байсныг гэрчилж байна.

Нөгөө талаас урсгал төлбөрийн тэнцэл алдагдалтай байгаа нь Монгол Улсыг өрийн дарамтад оруулж байна. Жишээлбэл, 2010-2020 онд урсгал дансны алдагдал дунджаар 2,299.0 ам.доллар болж, энэ хугацааны нийт алдагдлын дүн 25.3 тэрбум ам.долларт хүрч, 2020 оны эцсийн байдлаарх өрийн үлдэгдэл болох 32.4 тэрбум ам.долларын 78 хувийг эзэлж байна.

Монгол Улс жил бүр 140 орчим сая ам.долларын цахилгаан импортолж байна. Үүний дотор БНХАУ-аас 110 орчим сая ам.долларын цахилгаан авч, нүүрсээ машинаар тээвэрлэж, жил бүр 500.0 орчим сая ам.долларыг Тавантолгойгоос хил хүртэл тээврийн төлбөрт төлж байгаа зэрэг нь татвар ногдох орлогыг бууруулж байна. Энэ нь цахилгаан станц, төмөр зам барих ажлыг улам эрчимжүүлэх шардлагатайг харуулж байна. Төмөр замаар нэг тонн нүүрсийг 9 ам.доллаароор тээвэрлэх, автомашинаар 34 ам.долларын өртөгтэйгээр зөөхийн зөрүү 25 ам.доллар, Гашуун Сухайтаар 20 орчим сая тонн нүүрс гаргана гэж тооцоход дээрх алдагдал гарч байгаа юм. Манай улс 2010 онд 286.4 мянган тонн бензинийг 230.2 сая ам.доллаароор, дизелийн түлш 502.2 мянган тонныг 400.0 сая ам.доллар, нийтдээ 630.2 сая ам.доллар төлж байсан бол 2020 онд 586.1 мянган тонн бензинийг 244.7 сая ам.доллаароор, дизелийн түлш 1,026.9 мянган тонныг 432.4 сая ам.доллаароор, нийтдээ 681.1 сая ам.доллар төлж импортолсон байна. Энэ тоо үнийн дүнгийн хувьд нэг тэрбумаар нэмэгдэх нөхцөл бүрдэх эрсдэл нүүрлэж байна.

Сүүлийн 11 жилд үүсэж буй урсгал тэнцлийн алдагдлын 25.3 тэрбум ам.долларын 53 хувь буюу 13.9 тэрбум ам.доллар нь үйлчилгээний худалдааны алдагдал, 12.5 тэрбум ам.доллар буюу 49.4 хувийг анхдагч орлогын алдагдал бүрдүүлж байна. Харин хоёрдогч орлогын цэвэр нэмэх зөрүү болох 2.4 тэрбум ам.доллар нь буцалтгүй тусламж бөгөөд урсгал зардлын алдагдлыг нөхөх нөлөөтэй. Анхаарал татаж буй асуудал бол техник туслалцааны шинжтэй, хамгийн их алдагдалтай бизнес үйлчилгээ, үүний дараа тээвэр, аялал жуулчлал, барилгын үйлчилгээ, харилцаа холбоо орж байгаа явдал юм. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгтээс харж болно.

#### Хүснэгт 2а. Төлбөрийн тэнцэл (Сая ам.доллар)

Үзүүлэлт	Дундаж (2010-2020)	Нийт (2010-2020)	2021
<b>1.А.б Үйлчилгээ</b>	<b>-1,261</b>	<b>-13,866</b>	<b>-726</b>
1.А.б.1 Бусдын эзэмшлийн бүтээгдэхүүнд нэмэлт боловсруулалт хийх үйлчилгээ	-1	-8	2
1.А.б.2 Засварлалт болон угсралтын үйлчилгээ	-6	-68	0
1.А.б.3 Тээвэр	-280	-3,085	-9
1.А.б.4 Аялал жуулчлал	-276	-3,037	-342
1.А.б.5 Барилга, барилгын ажил үйлчилгээ	-160	-1,764	-63
1.А.б.6 Даатгал болон тэтгэврийн үйлчилгээ	-19	-210	-10
1.А.б.7 Санхүүгийн үйлчилгээ	-86	-947	-34
1.А.б.9 Харилцаа холбоо, компьютер, мэдээллийн үйлчилгээ	-63	-693	-68
1.А.б.10 Бизнесийн бусад үйлчилгээ	-337	-3,705	-169
1.А.б.11 Хувийн, соёлын, амралт чөлөөт цагийн үйлчилгээ	0	-4	0
1.А.б.12 Засгийн газрын бараа, үйлчилгээ	-17	-192	-14

Эх сурвалж: Монголбанк



Төсөв, төлбөрийн тэнцэл, өрийн байдалд нөлөөлж буй гол хүчин зүйлийг эхний ээлжинд манай орны хувьд төлбөрийн тэнцлийн судалгаагаар тогтоох учиртай билээ. Сүүлийн жилүүдэд экспорт нэмэгдэж, худалдааны тэнцэл нааштай болж буй ч гэсэн үйлчилгээ, анхдагч орлого, зарлагын тэнцэл алдагдалтай байна.

#### Хүснэгт 2б. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	2019	2020	Дундаж (2010- 2020)	Нийт (2010- 2020)	2021
<b>1.В Анхдагч орлого</b>	<b>-1,569</b>	<b>-1,253</b>	<b>-1,135</b>	<b>-12,486</b>	<b>-1,207</b>
1.В.1 Ажилчдын цалин	196	259	-16	-177	176
Орлого	307	314	116	1,279	214
Зарлага	110	56	132	1,457	37
1.В.2 Хөрөнгө оруулалтын орлого	-1,792	-1,521	-1,124	-12,364	-1,385
Орлого	59	16	17	190	13
Зарлага	1,852	1,538	1,141	12,553	1,398
1.В.2.1 Шууд хөрөнгө оруулалтын орлого	-946	-730	-620	-6,823	-867
1.В.2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн орлого	-465	-208	-262	-2,885	-534
1.В.2.1.1.1 Ногдол ашиг ба салбар компаниудын орлого	-214	-186	-254	-2,791	-186
1.В.2.1.2 Зээлийн хүүгийн орлого - Хүү 1	-481	-522	-358	-3,937	-333
1.В.2.2 Багцын хөрөнгө оруулалтын орлого	-380	-335	-186	-2,041	-206
1.В.2.2.2 Зээлийн хүүгийн орлого - Хүү 2	-380	-335	-186	-2,041	-206
1.В.2.3 Бусад хөрөнгө оруулалтын орлого	-502	-466	-324	-3,562	-315
1.В.2.3.2 Хүүгийн орлого - Хүү 3	-502	-466	-317	-3,483	-315
1.В.3 Бусад анхдагч орлого	27	9	5	55	2
<b>Нийт хүү</b>	<b>-1,363</b>	<b>-1,323</b>	<b>-860</b>	<b>-9,461</b>	<b>-853</b>

Эх сурвалж: Монголбанк

Дээрх мэдээллээс үзэхэд гадаад зээлийн хүүний үйлчилгээний төлбөрт сүүлийн 11 жилийн хугацаанд нийтдээ 9.5 тэрбум ам.доллар гадагш төлөгдсөний зэрэгцээ хэмжээ нь жил бүр өссөөр 2019 онд 1.36 тэрбум ам.доллар, 2020 онд 1.32 тэрбум ам.доллар тус тус болж, ойролцоогоор 3.5 их наяд төгрөгтэй тэнцэж, татвар ногдох орлогыг бууруулж байна. Энэ нь экспортын орлогын 20 шахам хувь, түүн дээр зээлийн үндсэн төлбөрийг оруулбал Азийн хөгжлийн банкны мэдээлсэнчлэн экспортын орлогын 50 хувьд дөхнө. Энэ үзүүлэлт Засгийн газраас ихэнх зээлийг дахин санхүүжүүлж, хойшлуулан бондын үндсэн төлбөр хийгдээгүй нөхцөлд гарч буй нь цаашдаа онцгой анхаарч ажиллахын томоохон дохио юм. Өөрөөр хэлбэл, бүх экспортоо өрийн үйлчилгээний төлбөрт зориулах хугацаа ойр байгаа учраас үүнээс сэргийлэх арга хэмжээг 2022 оноос эхлэн авч хэрэгжүүлэх шаардлагатай болжээ. Ирэх 2 жилд үүрэх бондын өрийн дарамтыг зохицуулсан, мөн зэс, төмрийн хүдэр, коксжих нүүрсний үнийн түвшин өндөр байна. Энэ нөхцөлд төсвийн алдагдалгүй болгож, хуримтлал бүрдүүлэх шаардлагатай.

Дээрх хүүгийн зардлаас төсөвт ирж буй ачаалал нь бараг нэг их наяд төгрөг болж байна. Иймээс төсөв, санхүүгийн бодлого тодорхойлоход хүү бууруулах, өр үүсгэхээс сэргийлэх стратеги хэрэгтэй болно. Төлбөрийн тэнцлийг алдагдалтай болгож өөр нэгэн хүчин зүйл анхдагч орлогын цэвэр алдагдал байна. Энэ бол манайд орсон хөрөнгө эргээд гадагшилж байна. Энэ үүднээс эхний ээлжинд гадаадын хөрөнгө оруулалтын байдлыг авч үзэж, тоо мэдээг 2020 оны байдлаар гаргаж, хавсралтын хүснэгт №3-д харуулав. 2020 оны эцсийн байдлаар нийт гадаадын хөрөнгө оруулалт 24.21 тэрбум ам.доллар байна. Үүний 11.41 тэрбум ам.доллар нь зээлийн хөрөнгө оруулалт болохыг хавсралтын хүснэгт №1-д харуулсан бөгөөд үлдсэн 12.8 тэрбум ам.доллар нь хувьцаа болон бусад өр үүсгэдэггүй хөрөнгө оруулалт байна. Нийт орсон хөрөнгө оруулалтыг эдийн засгийн салбарын ангиллаар нь авч үзэхэд уул уурхайд 17.7 тэрбум ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 73.13 хувь, банк санхүүгийн салбарт 0.95 сая ам.доллар буюу

3.95 хувь, худалдаа болон бусад үйлчилгээний салбарт 2.84 тэрбум ам.доллар буюу 11.72 хувь орсон байна. Бидний хүсэж буй боловсруулах салбарт 0.31 тэрбум ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 1.32 хувийг зориулж байгаагийн зэрэгцээ сүүлийн жилүүдэд огт нэмэгдээгүй байна. Хөрөнгө оруулалтын бодлогыг эргэн харж, дэс дараатай арга хэмжээ авах хэрэгтэй болжээ. Жишээлбэл, Монголын мал аж ахуйн түүхий эд бол байнга нөхөн төлждөг дундаршгүй эх үүсвэр юм. Үүнийг дэлхийн өндөр технологиор боловсруулж, олон улсын зах зээлд гаргахыг сангийн бодлогоор дэмжих хэрэгтэй байна. Тухайлбал, малын түүхий эдийг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн экспортод гаргавал 15-аас доошгүй жилийн турш орлогын татвараас чөлөөлөх, экспортыг санхүүжүүлэх эргэлтийн мөнгөн сан байгуулах, хүүний хөнгөлөлт үзүүлэх зэрэгт нийцсэн эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатайг харуулж байна. Байнгын нөөцөө олон жил найдвартай ашиглахын тулд хамгийн шилдэг технологийг монголдоо нутагшуулах, дэлхийн зах зээл дээр найдвартай борлогдох бараа бүтээгдэхүүн бий болгох, мэргэжлийн боловсон хүчин, инженер техникийн ажилтан бэлтгэх нь зүйтэй. Эдгээрт ихээхэн хугацаа, хөрөнгө оруулалт хэрэгтэй байна.

Төсвийн хүрээнд гардаг бас нэг сөрөг үзэгдэл бол төсвийн иж бүрэн байдлыг алдагдуулах явдал байна. Төрийн өмчийн компаниудаас “нийгмийн хариуцлага”, эсвэл “байгалийн баялгийг иргэдэд хүртээх” гэсэн нэрийдлээр Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан “төсвийн иж бүрэн байдлын зарчим”-г алдагдуулж, улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдмэл удирдлагыг хангахын оронд төсвийг олон суваг, хэрэгслээр зарж, төсвийн хяналтыг сулруулах, Сангийн яамыг тойрох гэсэн оролдлогыг анзаарч, зогсоох хэрэгтэй байна. Тухайлбал, Эрдэнэт үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд зарим аж ахуйн нэгж, суурин газрын иргэдийн цахилгаан, дулаан, ус, хогны төлбөрийг хариуцуулж байгаа нь 1.2 их наяд төгрөгт хүрэх тооцоо гарч байна. Мөн “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн ирээдүйд олох орлогыг барьцаалж, тэтгэврийн зээлийг тэглэхэд 694.9 тэрбум төгрөг, тэтгэврийн зээлгүй байсан ахмадуудад 1 сая төгрөгийн тэтгэмж олгоход 215.5 тэрбум төгрөг олгох зэрэг зардлуудыг дурдаж болох юм. Энэхүү буруу хандлагыг засаж, төсвийн иж бүрэн байдлыг хангаж ажиллах шаардлага үүсэж байна. Зарим салбарын төсвийг босоо тогтолцоонд шилжүүлэх болж байгаа нь эргэлзээ төрүүлж байна. Жишээлбэл, Эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, биеийн тамирын санхүүжилтийг босоо удирдлагатай болгосноор төсвийн зарлага буурахгүй, орон нутаг ямар ч үүрэг хариуцлага хүлээхгүй болохын хамт урьд орнуудад ийм журам тогтоосноос олигтой ахиц гараагүй, удирдлагын шат дамжлага, хүнд суртал нэмэгддэг байлаа. Иймээс орон нутгийн төр, захиргааны байгууллагуудын оролцоо, дэмжлэг, туслалцааг хэрхэн авах тухай сайтар бодох хэрэгтэй.

Төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн сахилгыг бэхжүүлэх, далд орлогыг илрүүлэхэд татварын бүртгэл, түүнийг нийгмийн халамжтай холбох нь чухал болно. Төсвөөс иргэд, түүний дотор хүүхдүүдэд олгож буй аливаа тусламж тэтгэлэг, нөхөн олговрыг тухайн иргэн, тэдний гэр бүлийн орлого, татварын төлөлттэй төдийлөн холбогдохгүй байгаа юм. Олон улсын шилдэг туршлага бол төрөөс олгох аливаа дэмжлэг, туслалцаа нь татварын тайлангаар голчлон тодорхойлогддог байна. Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 25.2-д хувь хүнийг татвар төлөгчөөр бүртгэж татвар төлөгчийн дугаар олгоно (иргэн) гэсэн зохицуулалтыг тусгасан. НӨАТ-ын хуулийн дагуу и-баримтын системд 2,063,608 иргэн бүртгэлтэй байна. ТЕГ-ын 2020 оны мэдээллээр ХХОАТ-ын хуулийн Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого (ТТ-11)-оор 675,134 иргэнээс суутганаар татвар ногдуулсан тайланг ирүүлсэн байна. Үйл ажиллагааны орлого олж буй 181,606 иргэн бүртгэлтэй боловч 21,489 иргэн нь тайлан ирүүлсэн байна. Хүн амын орлогын албат татварын хуулийн дагуу зарим татвар төлөгчид хөнгөлөлт,



чөлөөлөлт (орон сууцны, сургалтын төлбөрийн хөнгөлөлт) эдэлжээ. Татвар төлөгч иргэний бүртгэлийн дугаар нь хуульд заасан нэгдсэн дугаарт одоогоор шилжээгүй байна. Өнөөгийн байдлаар иргэний хувьд иргэний бүртгэлийн регистрийн дугаар, татвар төлөгчийн дугаар, нийгмийн даатгалын дэвтрийн дугаар гэсэн тус тусын дугаартай байгаа нь иргэний мэдээлэл бүртгэлийн нэгдмэл байдалд ороогүй байгаа ба татвар төлөх үүргийн биелэлт, нийгмийн халамж нь харилцан уялдаагүй явагдаж байгааг харуулна. Үүнийг цаашдаа нэгдсэн бүртгэлд оруулж, иргэдийн орлого, татварын тайлантай халамж, тэтгэлэг, хөнгөлөлтүүдийг холбох нь чухал болно.

Дээр дурдсан зарим тулгамдсан асуудлыг 2022 оны төсвийн хууль болон бодлогод хэрхэн тооцож тусгасныг авч үзье.

## ГУРАВ: ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2022 оны төсвийн хуулийн төслийг дагалдах бусад хуулийн төслүүдийн хамт өргөн мэдүүлсэн байна. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2021 онд 4.1 хувь, 2022, 2023 онд 5.0 хувь орчимд тогтворжих төсөөлөл хийснийг үндэстэй гэж үзлээ. Энэ оны эхний улирлаас эхлэн өссөн эрдэс түүхий эдийн үнийн түвшин 2022 онд бага зэргийн бууралттай ч харьцангуй тогтвортой байх төсөөллийг ОУВС хийжээ. Инфляц 2021 оны эхний улиралд 2.5 хувь байсан бол 4 сараас нэмэгдэж 8 дугаар сарын байдлаар 8.9 хувьд хүрлээ. Ийнхүү инфляц оны эцэст нэмэгдэх төлөвтэй байгаа хэдий ч ирэх оны 2 дугаар хагасаас тогтворжих хүлээлт бий.

Ирэх 2022 онд бизнесийн үйл ажиллагааг бүрэн нээж, эдийн засгийг сэргээх, гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортыг нэмэгдүүлэх, томоохон төслүүдийг эхлүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төслүүдийг түлхүү хэрэгжүүлж эдийн засгийг тэлэх, “Хөдөлмөр, бүтээмж, өсөлт”-ийг дэмжих төсвийн бодлого хэрэгжүүлэх зорилт тавьжээ. Засгийн газраас Монгол Улсын 2022 оны төсвийг боловсруулахдаа дараах багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Хөгжлийн төслүүдийг эхлүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих замаар эдийн засгийг сэргээх шинэчлэл хийх, төрийн өмчит хуулийн этгээдийн ашигт ажиллагаа, засаглал, ил тод байдал, хариуцлагыг сайжруулж төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх зорилгоор засаглал, бүтцийн өөрчлөлт, ногдол ашгийн бодлогын шинэчлэлийг ирэх онд хэрэгжүүлэхээр тооцсон байна.

- Мөн төр өөрийн зардлаа хэмнэх, оновчтой байдлаар дахин хуваарилах, төрийн үйлчилгээг цахимжуулах зэргээр бүх шатны байгууллагуудыг хэмнэлтийн горимд ажиллах, хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой чиг үүргийг төр хэрэгжүүлдэг байдлаас татгалзаж стандарт, чанар, өрсөлдөөнд суурилсан үйлчилгээг төр худалдан авах, нийгмийн суурь үйлчилгээний байгууллагуудыг төсвийн хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх зэргээр цомхон, чадварлаг хариуцлагатай төрийн албыг бүрдүүлэх зорилт тавьжээ.

- Байгалийн баялгийн хүртээмжийг нэмэгдүүлж, ирээдүй хойч үедээ өвлүүлж, санхүүгийн баталгаатай, “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэх чадвартай, орлого багатай иргэдийг халамжаар бус, ажил эрхлэлтээр дэмжихэд чиглэсэн “халамжаас-хөдөлмөрт шилжих шинэчлэл” хийх зорилт дэвшүүлсэн байна.


- Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд төгрөгийн хөтөлбөрийг дараагийн жилүүдэд үргэлжлүүлэх ажээ. Энэ хөтөлбөрийн ажлын байрны дэмжлэг үзүүлэх хэсгийн хүрээнд зээл авсан аж ахуйн нэгжийн 6 нэгж хувь, иргэний 7 нэгж хувийг төрөөс хариуцаж байхаар зохицуулсан байна. 2021 онд

ажлын байрыг дэмжих зээлийн хүүгийн зөрүүд 98.9 тэрбум төгрөгийг олгож, 2022 оны төсвийн төсөлд 210.1 тэрбум төгрөг тусгажээ.

Эдгээр зорилтууд хэрхэн хэрэгжих нь төсвийн орлого, зарлагын бодлого, арга хэмжээнээс ихээхэн хамааралтай билээ.

**Төсвийн орлогын талаар:** Төсвийн орлого, түүний дотор шууд бус татварууд, хүн амын болон аж ахуйн нэгжийн орлогын татварын хэмжээг баримжаалах үүднээс ДНБ-ийг орлогын аргаар тооцоолон зэрэгцүүлж, динамик судалгаа хийж хавсаргав.

**Зураг 2. Төсвийн орлого, түүний ДНБ-д эзлэх хувь**




Эх сурвалж: Сангийн яам

Дэлхийн зах зээл дээр зэс, төмөр зэрэг эрдэс, түүхий эдийн үнийн өссөн мөчлөг энэ онд тохиож буй бөгөөд 2022 онд энэ хандлага огцом буурахгүй байх таамаглал хийж, төсвийн орлогыг нэмэгдүүлж, ДНБ-ний 30 гаруй хувьд хүрэхээр төсөл боловсруулжээ. ДНБ-ийг орлогын аргаар тооцоолон төсвийн орлогыг харьцуулж үзэхэд нийт борлуулалт, импортоос хамааралтай шууд бус татваруудын хэмжээ ихээхэн өссөн байна (Зураг 3).

Төсвийн орлогоос нийт үйлдвэрлэл, экспорт, импортын үнийн дүн хэмжээнээс хамаардаг нэмүү өртгийн албан татвар, байгалийн нөөц ашиглалтын албан татвар, гаалийн татвар, газрын тосны зэрэг татварууд 2020 оноос 86.0 хувь, 2021 оны тодотгосон төлөвлөгөөнөөс 46.4 хувиар тус тус өсөхөөр байна.

**Зураг 3. 2012-2022 оны татварын орлогын өсөлт (тэрбум төгрөг)**



Эх сурвалж: Сангийн яам

Энэ нь зэс, төмөр, газрын тос зэрэг таваарын бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс давахгүй байгаа тул дээрх төрлийн татварын орлого үндэслэлтэй төлөвлөгдсөн гэж үзлээ. Гагцхүү тоо хэмжээний тасалдал гаргахгүй байхад онцгой анхаарах шаардлагатай. Ялангуяа олон нийлүүлэгчтэй болсон Хятадын коксжих нүүрсний импортын зохих хэсгийг урьдын адил манай талаас хангахад онцгой анхаарах шаардлага тулгарсан. Үүний тулд Таван толгойгоос Хятадын хил рүү, Зүүнбаян руу тавих замыг яаралтай барьж дуусгах хэрэгтэй байна.

Хорио цээр, хилийн дэглэм, улс орны харилцааны асуудлаар нэн оновчтой бодлого явуулах шаардлагатай болж байна. Хавсралт Хүснэгт №6 дахь нүүрсний судалгаанаас үзэхэд сүүлийн 2016-2020 онуудад нийт нүүрсний экспортын 52.3 хувь буюу 83.4 сая тонныг Таван толгойгоос Гашуунсухайт боомтоор гаргажээ. Энэ боомтод онцгой анхаарал тавьж ажиллах, төмөр замын бүтээн байгуулалтыг аль болох эртхэн дуусгах нь чухал болно.

Монгол Улс 2023 онд 36 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөсөн нь сүүлийн 5 жилд хамгийн өндөр байсан 2019 оны экспортын нийт хэмжээтэй дүйж байна. Энэ онд Гашуун сухайтаар 20.5 сая тонн нүүрс гарч байсан бөгөөд ийм хэмжээний буюу үүнээс дутахгүй тооны нүүрс тээвэрлэх хүчин чадал бүхий төмөр зам, зүтгүүр, вагон, контейнерийн хөрөнгө оруулалт, түүний эх үүсвэр зэрэг нь 2022 оны төсөв төлөвлөгөөнд тусгалаа олсон гэж ойлгож байна.

Ирэх онд экспортын гол бүтээгдэхүүн болох зэсийн үнийг 8,915.6 ам.доллар, алтны дундаж үнийг 1,821 ам.доллар, нүүрсний үнийг 130-140 ам.доллар байхаар тооцож орлогыг төлөвлөснөөс харахад ирэх онд төсвийн орлогыг өөдрөгөөр, бодож төлөвлөсөн байгаа юм.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 16,415.1 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2021 оны төсвийн тодотголын дүнгээс 2,683.4 тэрбум төгрөг 16.3 хувиар өсөж, ДНБ-ий 35.1 хувьтай тэнцэхээр байна. 2022 оны төсвийн төсөлд тусгаснаар нийт орлогын 84.9 хувь буюу 13,941.3 тэрбум төгрөгийг татварын орлого, 11.2 хувь буюу 1,830.4 тэрбум төгрөгийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөлд татварын орлогыг 2021 оны тодотгосон төсвөөс 19.5 хувиар буюу 2,683.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр төлөвлөжээ. Оюутолгойн далд уурхай, Тавантолгойн цахилгаан станц, газрын тосны бүтээгдэхүүн дамжуулах хоолой, Богдхан төмөр зам, улсын чанартай томоохон төмөр зам, авто замын төслүүдийг хэрэгжүүлж эхлүүлэхээр тооцсонтой холбогдуулан татварын суурь өснө гэж тооцоолсон байна.

Татварын орлогыг бүтцээр нь авч үзвэл нийт татварын орлогод орлогын албан татвар 21.0 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 24.7 хувь, нийгмийн даатгалын шимтгэл 21.4 хувь, онцгой албан татвар 8.1 хувь, гаалийн албан татварын орлого 7.8 хувь, бусад татвар, төлбөр хураамж 15.4 хувь, хөрөнгийн албан татвар 1.5 хувь, тусгай зориулалтын орлого 0.1 хувийг тус тус эзлэхээр байна. Татварын орлогын ДНБ-д эзлэх хувийн жин буюу татварын ачааллыг тооцож үзвэл 2022 онд 29.8 хувь байхаар байна.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд татварын бус орлогоор 1,830.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн нь 2021 оны тодотгосон төсвөөс 399.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна. Энэ нь хувьцааны ногдол ашиг 409.2 тэрбум, газрын тосны орлого 64.3 тэрбум, хүү торгуулийн орлого 51.1 тэрбум, навигацийн орлого 27.1 тэрбум төгрөгөөр тус тус өсөхөөр төлөвлөсөнтэй холбоотой байна.

Дэлхийн зах зээл дээр нүүрс, алт, зэс, төмрийн хүдрийн үнийн төсөвт авсан төсөөллөөс үнэ буурвал орлогын эрсдэл үүснэ. Үүний зэрэгцээ манай орны нүүрсний гол хэрэглэгч болох БНХАУ нүүрсний олон нийлүүлэгчидтэй болсны зэрэгцээ хэрэглээг багасгах зорилт дэвшүүлээд байгааг анхаарч үзэх ёстой. Үүний зэрэгцээ экспортын бүтээгдэхүүнээ гаргах боомтуудын үйл ажиллагаа тогтворжоогүй, дэд бүтэц сул байгаа нь тавьсан зорилтоо хэрэгжүүлэх боломжид эрсдэл үүсгэхээр байгаа юм. Урд хөрш рүү гаргах нүүрсний тээврийн вагоны зам тавигдаж байгаа боловч хилээр хэрхэн нэвтрүүлэх талаар Засгийн газар тодорхой шийдэлд хүрэхгүй байгаа нь эрсдэл үүсэх бас нэг нөхцөл болж байна. Иймээс төсвийн нийт орлого, зарим татварын орлогын өсөлт бууралтыг тусгайлан авч үзэж ерөнхий шинжилгээ хийж үзлээ.

Уул уурхайн салбараас төвлөрүүлэх орлого 4,261.8 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөгдсөн нь төсвийн нийт орлогын 26.0 хувийг бүрдүүлэхээр байна. 2022 онд дээр хэлсэнчлэн 36.7 сая тонн нүүрс экспортолж 1,594.0 тэрбум төгрөг, Монголбанкинд тушаасан 20 тонн алтнаас 235.6 тэрбум төгрөг, тонн тутамд 8,915.6 ам.доллараар тооцон 1.2 сая тонн зэсийн баяжмал экспортолж 1,836.1 тэрбум төгрөг, бусад эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортоос 595.9 тэрбум төгрөгийн орлого тус тус төвлөрүүлнэ гэж үзжээ.

Уул уурхайн салбарын орлогын гол нэр төрөл болох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр дамжуулан 2022 онд нийт 2,151.7 тэрбум төгрөгийн орлогыг төсөвт, үүний дотор Ирээдүйн өв санд 1,471.6 тэрбум төгрөг (АМНАТ 1,057.2 тэрбум төгрөг, ногдол ашиг 404.5 тэрбум төгрөг) төвлөрүүлэхээр төсвийн төсөлд тусгажээ. Манай орны төсөв өөрөө алдагдалтай байхад тэнд төвлөрсөн, эсвэл төвлөрөх орлогоос тусгайлсан сан байгуулах ач холбогдолгүй бөгөөд эцсийн дүндээ төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, эсвэл эдийн засаг, нийгэм, халамжийн чиглэлийн арга хэмжээнд зарцуулаад дуусаж байгааг өмнөх жилүүдийн туршлага харуулж байгаа. Өнөөг хүртэл Монгол Улс эдийн засгийн хөгжлийн, хүний хөгжлийн, төсвийн тогтвортой байдлын сан, ирээдүйн өв сангийн зэрэг сангуудыг төрийн мэдэлд байгуулах оролдлого хийж ирсэн бөгөөд тэдгээрийг зарцуулах үндэслэлийг төр, засгаас олж байна. Иймээс уул уурхайн баялгийн өгөөжийн тодорхой хэсгийг засаг, төрийн мэдэлд бус хувь хүний, хүүхдийн мэдэлд хадгаламж хэлбэрээр үлдээх нь манай орны хувьд дэмжүүштэй, уул уурхайн баялаг бүхий орнуудын шилдэг туршлага болно.

Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу байгуулах Үндэсний баялгийн санг мөн төсвийн бүрэлдэхүүнд оруулж, орлого, зарлагын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх учиртай. Үндсэн хуульд заасан газрын хэвлийн баялгийн өгөөжийг баялгийн санд “төвлөрүүлэх” гэдэг нь хуульд заасан бүх төрлийн татвар хураамж

байх болно гэж ойлгож байгаа. Түүнээс биш баялгийн өгөөжийн үр дүнд бий болох хувь хүний цалин, өдөр тутмын хэрэглээний зарим биет зүйл, аж ахуйн нэгжийн орлогыг бүгдийг төвлөрүүлэх эрх зүйн үндэс байхгүй юм.

ТТБЗ-ийн гишүүдийн үзэж байгаагаар энэхүү Үндэсний баялгийн сан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн салшгүй хэсэг бөгөөд үүний төлөө нийт засаг захиргааны нэгж, Сангийн яам, Монгол Улсын Засгийн газар, Ерөнхийлөгч ажиллаж, Үндсэн хуулийн “нэгдсэн удирдлагатай байх”, “үндэсний эв нэгдлийг хангах” зарчмуудыг хатуу мөрдлөг болгодог гэж ойлгож байна.

**Төсвийн зарлагын талаар:** Төсвийн зарлагын хувьд Засгийн газар төсвийн төсөлд төсвийн зарлагыг 18.2 их наяд төгрөгөөр, урсгал зардлыг 13.3 их наяд төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 2.8 их наяд төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 264.0 тэрбум төгрөгөөр төлөвлөжээ. Төсвийн нийт зарлагыг 2022 онд 2021 оны тодотголоор батлагдсан төсвийн нийт зарлагаас 2,410.5 тэрбум төгрөг буюу 15.3 хувиар өсөхөөр төлөвлөсөн байна. Үүний дотор хөрөнгийн зардал 1,752.6 тэрбум төгрөг буюу 52.1 хувиар 2022 оны төсвийн төсөлд нэмэгдэж тусгагджээ. ДНБ-д урсгал зардлын эзлэх хувь 2.4 пунктээр буурсан бол ДНБ-д эзлэх хөрөнгийн зардлын хувь 2.9 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр шатахуун, гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, ном хэвлэл худалдан авах, хэвлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, байгууллага салбарын ой тэмдэглэх, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, кино уран бүтээл хийх, шинээр авто машин худалдан авах зардлыг хязгаарлахаар төлөвлөснийг дэмжиж байна.

Нэгдсэн төсвийн урсгал зардлын 30.6 хувь буюу 4,065.7 тэрбум төгрөгийг бараа, үйлчилгээний зардалд, 62.2 хувь буюу 8,282.3 тэрбум төгрөгийг татаас ба урсгал шилжүүлэгт, 7.2 хувь буюу 959.3 тэрбум төгрөгийг зээлийн үйлчилгээний төлбөрт зарцуулахаар төсвийн төсөлд тусгажээ. Дээрх 4 тэрбум гаруй төгрөгийн бараа үйлчилгээний ихэнхийг цар тахлын үед голчлон эх орныхоо аж ахуйн газруудаас худалдан авах зорилт тавьж, нарийвчилсан судалгаа хийхийг Засгийн газар, бүх шатны засаг захиргааны байгууллагуудад санал болгож байна.

Уул уурхайн орлого өссөн он жилүүдэд цалин нэмэгдүүлэх, тэтгэврийн зөрүүг багасгах, дэд бүтэц, нийгмийн чиглэлтэй төсөл, хөтөлбөрүүд багагүй хэрэгжсэн ч хавтгайрсан бэлэн мөнгөний олголт 2008 оноос нэмэгдэж, ямар нэг хэмжээгээр өнөөг хүртэл үргэлжилсэн хэвээр байна. Харин Засгийн газраас 2022 оноос эхлэн хавтгайрсан халамж тэтгэлгийг хязгаарлаж, зорилтот бүлэгт чиглүүлэх, ажлын байр, хуримтлал бий болгох, хөрөнгө оруулалтад илүү анхаарах зорилт тавьж байгааг дэмжиж байна.

2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүүхэд бүрд сар бүр 100.0 мянган төгрөгийг олгож байна. Үүнийг цаашид Ирээдүй өв сангийн хөрөнгийн хэмжээнд багтаан хүүхдэд хуримтлал болгон хүртээх ажээ. Үүний тулд Ирээдүйн өв санг нэгдсэн төсвийн бүрэлдэхүүнд оруулж тус сангийн тухайн жилийн орлогын эх үүсвэрийг хүүхдийн удаан хугацааны хадгаламжийг бүрдүүлэхэд ашиглаж, хүүхдийн энэ хадгаламжид аливаа хадгаламжийн нэгэн адил хүү боддог байна гэж ойлгож дэмжиж байгаа. Засгийн газраас 2022 оны төсвийн баримт бичигт тусгаснаар Монгол Улсын хүүхэд бүр Ирээдүйн өв сангаар баталгаажсан, Хадгаламжийн даатгалын сангаар даатгуулсан, хамгийн эрсдэл багатай системийн нөлөө бүхий банкуудад хадгаламжийн дансны хуримтлалтай болж, хадгалах, хуримтлуулах дадал зуршлыг хүүхэд наснаас суралцахаас гадна 18 нас хүрээд нэрийн дансны хуримтлалаар өөрийн боловсролдоо хөрөнгө оруулалт хийх боломж нь нээгдэх ажээ. Иймээс Ирээдүйн өв сан, хүүхдийн хуримтлалыг удирдах бүтэц хэрэггүй

бөгөөд жирийн хадгаламжийн адил тооцогдож, арилжааны банкуудын урт хугацаат хөрөнгийн эх үүсвэр болно гэсэн дүгнэлтэд хүрсэн болно.

Гэхдээ орлого багатай зарим гэр бүлд огцом хүндрэл учруулахгүй байх үүднээс 2022 оны хувьд тодорхой хэмжээний мөнгийг хадгаламжаасаа авах сонголт өгөхөөр тооцсон байна. Тодруулбал, 2022 оны төсвийн жилд, 01 дүгээр сарын 01-ээс 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд сар бүрийн хуримтлалаа бүрэн ашиглах, цаашдаа он дуустал 50 хүртэл хувийг нь ашиглах боломжийг хүүхдүүд, тэдний эцэг эхэд олгох ажээ. Харин хүүхэд бүрд нийт 100.000 төгрөг гэсэн зарчмыг хадгална гэдэг нь эргэлзээтэй байна. Эх үүсвэрийн хэмжээнд нь хүүхдийн хадгаламжийг нэмэгдүүлж байх нь зүйтэй биз ээ.

Ирэх 2022 онд Ирээдүйн өв сангийн орлогын гол эх үүсвэр болох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 1,057.2 тэрбум төгрөг, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгаар 404.5 тэрбум төгрөг нийтдээ 1,461.7 тэрбум төгрөгийг 2022 онд тус санд төвлөрүүлж хүүхдийн мөнгөн хадгаламж бий болгохоор тусгажээ. Ногдол ашгийн үндэслэлийг нарийвчлан авч үзэх хэрэгтэй гэж үзэж байна.

**Хөрөнгө оруулалтын талаар:** 2022 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын зардлыг 5.1 их наяд төгрөгөөр төлөвлөжээ.

Засгийн газар хөрөнгө оруулалтын төслийг боловсруулахдаа Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дунд хугацаанд төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг тогтвортой түвшинд хадгалж, эдийн засгийн идэвхжлийг үргэлжлүүлэн дэмжих зарчим баримталж, төслүүдийг хөгжлийн бодлого, бүс, орон нутгийн хэрэгцээтэй уялдуулах бодлогыг хэрэгжүүлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг хангах зорилгоор боловсруулжээ. Мөн Боловсрол, эрүүл мэндийн салбарыг үргэлжлүүлэн дэмжиж, төвлөрлийг сааруулах төслүүдийг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн байна. Төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө цахим системийн дагуу үнэлгээ хийгдсэн төслүүдийг төлөвлөх, батлагдсан зураг төсөвтэй, газрын асуудал шийдэгдсэн байх зарчмыг баримтлан ажилласан байна.

2022 оны төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад 5.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2022 онд санхүүжих 2.1 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 1,334 төсөл, арга хэмжээ тусгагдсан байна. 2022 онд хөгжлийг дэмжих арга хэмжээнд Залуу гэр бүлийг орон сууцжуулах зорилтын хүрээнд: "Залуус-1" орон сууцны хорооллын төслийн гадна инженерийн шугам сүлжээний төсөлд 29.9 тэрбум төгрөг, "Аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтцийн төсөл"-д 100.0 тэрбум төгрөг, "Сум, суурин газрын цахилгаан хангамж, шугам сүлжээ, дэд бүтэц" төсөлд 12.0 тэрбум төгрөг, "Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж" төсөлд 45.9 тэрбум төгрөг, Эдийн засгийн өсөлтийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлэх зорилтын хүрээнд нийт 455.6 тэрбум төгрөг төлөвлөжээ. Хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөхдөө зураг, төсөлгүй төсөл, арга хэмжээг төсвөөс хасах нь зүйтэй гэж үзэж байна.

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, жагсаалтаас үзэхэд дараах зайлшгүй анхаарах, төсөлд өөрчлөлт оруулах шаардлагатай асуудлууд байна гэж ТТБЗ үзлээ. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтыг төлөвлөлтийн аргачлалаар 16 шалгуур үзүүлэлтээр эрэмбэлэн тэргүүн ээлжид хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгө оруулалтыг төсөлд тусгасан гэх боловч 2022 онд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын нэлээд нь дээрх шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй байна.



Цаашид нөхөн үйлдвэрлэлийг болон төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төслийг төлөвлөгөөгүй гэж үзэж болохоор байна. Ялангуяа аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалт гэж үзэх тоймтой төслийг жагсаалтад тусаагүй байна. Төлөвлөсөн нийт 2,137.0 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 1,334 төсөл, арга хэмжээний 80-90% нь цаашид нэн тэргүүнд төсвийн зарлагыг нэмэгдүүлэхэд хүргэхээр байна.

Материаллаг үйлдвэрлэлийн голлох яамдын хөрөнгө оруулалтын төслөөр бол жишээ нь Барилга, хот байгуулалтын сайдын хариуцах хөрөнгө оруулалтын төслийн 80 орчим хувь нь барилга (*гудамж төсөл, сум, багийн тохижилт, тоглоомын талбай, орон сууцны болон гэр хорооллын шугам, гудамж талбайн тохижилт, нийтийн эзэмшлийн орон сууцны засвар, тохижилт г.м*) байгаа ч барилгын материалын үйлдвэртэй холбоотой хөрөнгө оруулалт байхгүй, Зам, тээврийн сайдын төслийн 90 хувь нь зөвхөн авто замын барилга, байгууламж, Уул уурхайн хүнд үйлдвэрлэлийн сайдын багцад ямар ч материаллаг үйлдвэрлэлийн санхүүжилт байхгүй, Ерөнхий сайдын хариуцах хөрөнгө оруулалт бараг 100 хувь (97 хувь) биеийн тамирын төсөл, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн хөрөнгө оруулалтын төсөлд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд зориулах санхүүжилтгүй атлаа гүний худаг, үйлчилгээний төвийн барилга, бэлчээрийн усан хангамж зэрэг үйлдвэрлэлийн бус барилга, байгууламжид 50 шахам тэрбум төгрөг зориулахаар төлөвлөсөн жишээтэй байна. Үүний зэрэгцээ боловсрол, эрүүл мэндийн салбарт зарцуулах хөрөнгө оруулалтын 80-90 хувь нь цаашдаа төсвийн зарлагыг өсгөнө. Товчхоноор дүгнэхэд зөвхөн төсвийн талаас нь авч үзэхэд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үлэмж их хувь нь цаашид төсвийн зарлагыг өсгөж, харин орлогыг нэмэгдүүлэхэд дорвитой нөлөөлөхгүй байхаар харагдаж байна.

2. Төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөлтийн аргачлалаар, цахим системд суурилсан үр ашигтай байх хэмжээнд орон нутаг, салбарын яам, Сангийн яам гэсэн гурван түвшинд 2 үе шаттай төлөвлөж, 5,334 төсөл, арга хэмжээнээс 1,334-ийг шалгаруулсан талаар бичсэн байна. ТТБЗ-ийн үзэж буйгаар эрэмбэлэгдэн шалгарч үлдсэн гэж дээрх 1,334 төсөл, арга хэмжээг бүгдийг төсвөөс 2022 онд санхүүжүүлэх нь учир дутагдалтай байна.

3. Төсөлд “тойргийн хөрөнгө оруулалтаас хөгжлийн хөрөнгө оруулалт руу шилжилт хийж, зам, тээврийн салбарын хөрөнгө оруулалтыг 7.5 дахин, барилгын салбарынхыг 4.1 дахин, эрчим хүчийг 6.4 дахин өсгөхөөр төлөвлөлөө” гэжээ. Авто замын төслүүдийн сонголт нь эргэлзээтэй харагдаж байна. Зам, тээврийн төсвийн хөрөнгө оруулалтын 90 хувь авто зам, барилгын салбарын хөрөнгө оруулалтын 76 хувь нь барилга, байгууламжийн хөрөнгө оруулалт байна. Эдгээр нь улс орны хөгжлийн гол, тэргүүн зэргийн зорилт уу, эдгээрээс илүү улс орны хөгжилд ач тустай хөрөнгө оруулалтыг яам, төсвийн эрх захирагчид төлөвлөхгүй байгаа юм уу гэсэн асуулт урган гарч байна.

4. Засгийн газрын урсгал зардал нэмэгдүүлдэг төслүүдийг бууруулах, контор болон автомашин худалдан авах төслийг огт тусгахгүй байх бодлого барьсан гэсэн боловч хөрөнгө оруулалтын жагсаалтаар бол энэ бодлого нь хэрэгжээгүй, тойргийн хөрөнгө оруулалт нь үргэлжилсээр байна.

5. Концессын “барих-шилжүүлэх” нөхцөлөөр 2016-2020 онд 5 жилд нийт 786.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн. Гэтэл 2022 онд үүний 40 хувьтай тэнцэх 7 төсөлд 303.6 тэрбум төгрөг төлөвлөснийг сайтар нягтлан үзвэл зохино. Ялангуяа шинээр эхлэх автозам, автомашины зогсоолыг заавал концессын гэрээгээр гүйцэтгүүлэх шаардлагагүй, Засгийн газрын концессын өр 1 их наяд төгрөгөөс давж, 2021-2022 онд хамгийн өндөр өсөлттэй өр болсон байгааг онцгой анхаарах

шаардлагатай. Энд “барих-шилжүүлэх” нөхцөлтэй концессыг хязгаарлах хуулийн заалтыг чанд мөрдөж ажиллах нь чухал.

6. Эдийн засгийн өсөлтийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Дорнод (Хэрлэн сум-Хавиргын боомт), Төв (Угтаал цайдам, Цээл, Заамар сумд хооронд), Өндөрхаанаас Ульхан боомт хүртлэх авто замуудад 455.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна. Эдгээр авто зам нь экспортыг хэрхэн нэмэгдүүлэх вэ? Ийм чухал зам уу? Зам хаана ч хэрэгтэй нь ойлгомжтой ч эхний ээлжийнх байх уу? Цаашид ашиглалт, засвар, үйлчилгээнд төсвөөс хөрөнгө шаардана (Эдгээр зам экспортод нөлөөлөх эсэхийг тооцох хэрэгтэй).

7. 2020 онд төлөвлөсөн төсвийн хөрөнгө оруулалтын 18 хувь болох 1,093.6 тэрбум төгрөгийн хэрэгжээгүй, санхүүжилт нь эхлээгүй 197 төсөл, арга хэмжээ (92 тэрбум төгрөг) байсан. Эдгээр төсөл 2021 онд хэрэгжиж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

8. “Улсын хэмжээнд” гэдэг нэрээр төлөвлөсөн 178.6 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 21 төсөл, “нийтийн эзэмшлийн” нэрээр төлөвлөсөн 19 орон сууцны засвар (12.5 тэрбум) зэргийг сайтар хянаж, төсвийн хөрөнгө оруулалтын зарчимд нийцэх эсэхийг тогтоох шаардлагатай гэж үзэж байна.

9. Төсвийн хөрөнгө оруулалтыг Улсынхаа эдийн засагт оруулах ач холбогдлоор эрэмбэлж, эдийн засгийг тэлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, экспортыг өсгөх төсөлд чиглүүлсэн гэх боловч чухам хэдэн төсөл, яаж нөлөөлөх талаар тодорхой судалгаа харагдахгүй байна. 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд томоохон объект, үйлдвэрлэл, экспортын бүтээгдэхүүнийг дэмжсэн төсөл харагдахгүй байна. Хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлт гаргасан байхыг шаарддаг боловч энэ төрлийн тооцоо, дүгнэлт байхгүй байгааг цаашид онцгой анхаарч хуулийн заалтыг мөрдөж, ийм үйлдэл гаргахгүй байх нь зүйтэй.

**Төсөв хоорондын харилцааны талаар:** Орон нутгийн төсвийн хувьд 2022 оны төсвийн жилд орон нутгийн нийт орлого, зарлага өмнөх онуудаас буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагуудын санхүүжилтийн зарчим, арга, хэлбэрийг өөрчилж улсын төсвөөс шууд санхүүжүүлэх өөрчлөлтийг хийхээр төлөвлөсөнтэй холбоотой байна.

Орон нутгийн суурь орлого нэмэгдсэн нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (ЗЗНДНТУТХ)-ийн шинэчилсэн найруулга болон түүнийг дагаж батлагдсан Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 100 хувь улсын төсөвт төвлөрүүлдэг байсны 40 хувийг аймаг, нийслэлийн төсвийн татварын орлогод шилжүүлэн төвлөрүүлэх болсонтой холбоотой байна. Орон нутгийн суурь зарлагыг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан чиг үүргүүдийг ЗЗНДНТУТХ-ийн 3 дугаар бүлгийн нэгдүгээр дэд бүлгээр зохицуулах болсонтой холбогдуулан нэмэгдүүлж тооцсон байна.

Монгол Улсын ЗЗНДНТУТХ-ийн шинэчилсэн найруулга, түүний дагуу Төсвийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр *Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн* зохицуулалтад дараах өөрчлөлтүүд орохоор төлөвлөгджээ. Үүнд:

1. ОНХНС-д *ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн* эх үүсвэрээс төвлөрөх хэмжээг 5 хувь байсныг 10 хувь болгон нэмэгдүүлсэн;

2. Импортоос бусад бараа, ажил үйлчилгээний *нэмэгдсэн өртгийн албан татварын* орлогын эх үүсвэрийг хассан;

3. Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аймагт байгаль орчны нөхөн сэргээлт хийж иргэдийн амьдрах орчныг сайжруулах зорилгоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон *газрын тосны нөөц ашигласны төлбөрийн* орлогоос тодорхой хэсгийг тухайн эх үүсвэр бүрдүүлж байгаа аймгуудад нэмэлтээр хуваарилсан;

4. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15.1.5-д заасны дагуу Төсвийн тухай хуульд заасан *хүн амын тоо, нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг* харгалзан хуваарилсан;

5. Аймгийн ОНХС-аас сумдын *ОНХС-д хийгдэх шилжүүлгийн суурь дүнг 30 хувиас 50 хувь болгон нэмэгдүүлсэн.*

Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлдэг *тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан зарчим, арга, хэлбэрт өөрчлөлт оруулж боловсрол, эрүүл мэндийн байгууллагыг хагас бие даалган* улсын төсвөөс шууд санхүүжүүлэх, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27.1 болон Төсвийн тухай хуулийн 61.1-д заасны дагуу орон нутаг дахь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Соёлын хэлтсийг тус тус босоо хэлбэрээр улсын төсвөөс шууд санхүүжүүлэх болсон байна.


Ийнхүү Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлж байсныг улсын төсөвт төвлөрүүлэн хуваарилахаар зохицуулалт хийсэн нь бодит амьдралд нийцэхгүй шийдэл гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн суурь үйлчилгээ болох СӨБ, ЕБС, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээ зэрэг үйлчилгээнд орон нутаг 2021 онд 1.4 их наяд төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэг хэлбэрээр зарцуулж дээрх чиг үүргүүдийг хэрэгжүүлж байсан. Харин 2022 оноос эхлэн тухайн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн төсөвт төвлөрүүлэн хуваарилах болсон нь чанар, үр дүнг чухалчлан төсвийг түүнтэй уялдуулах сайн талтай хэдий ч бодлогын энэ шинэчлэлийн бэлтгэл бүрэн хангагдаагүй байгаа төдийгүй төсвийн төвлөрлийг нэмэгдүүлж, орон нутгийн бие даасан байдал алдагдахад сөрөг нөлөөтэй гэж үзэж энэхүү зохицуулалтыг дэмжихгүй байна.

***Нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт:*** Дээр дурдсанчлан төсвийн алдагдал, өрийн хязгаарыг тогтоосон хуулийн заалтыг байнга өөрчлөн төсвийн зарлагыг нэмэгдүүлж ирсэн тул төсвийн үр дүн хүссэн хэмжээнд хүрэхгүй байна. Төсвийн дүрмийг хуульчлан тогтоосон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг 2010 онд баталсан бөгөөд түүнээс хойших 11 жилд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 14.8 их наяд төгрөг болж, 2020 оны эцсийн байдлаарх Засгийн газрын нийт өр болох 27.9 их наяд төгрөгийн өрийн үлдэгдлийн 50 гаруй хувийг эзэлж байна.

Сүүлийн жилүүдийн нэгдсэн төсвийн үр дүнгийн байдлыг хавсралтын хүснэгт №5-д үзүүллээ. Төсвийн байдал 2018, 2019 онд нэлээд сайжирсан боловч 2020, 2021 онд ихээхэн хүндэрсэн байдалтай харагдаж байна. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2.4 их наяд төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөжээ. Үүний 1.4 тэрбум төгрөгийг гадаадын зээлээр санхүүжүүлж, үлдсэнийг нь тогтворжуулалтын санд төвлөрөх 0.64 тэрбум төгрөг болон бонд гаргах замаар санхүүжүүлэхээр тооцсон байна.

Таваарын бүтээгдэхүүний үнэ өндөр болсон 2005-2007 онуудад төсөв, төлбөрийн тэнцэл хоёулаа ашигтай гарч байжээ. Таваарын бүтээгдэхүүнийг төлөөлүүлэн, тухай үеийн орлогын гол эх үүсвэр болсон зэсийн үнийн өөрчлөлтийг дараах зурагт харуулав.

#### Зураг 4. Зэсийн жилийн дундаж үнэ (ам.доллар)



Эх сурвалж: Лондонгийн бирж

Сүүлийн жилүүдэд Засгийн газраас дотоодын өрийн бичиг (бонд)-ээр үүссэн өрийг барагдуулахад илүүтэй анхаарч иржээ. Бонд гаргахгүй, төлбөр барагдуулж байсан нь нэгдүгээрт өндөр хүүтэй зээл төсөвт ихээхэн ачаалал өгч байсан, хоёрдугаарт банк, санхүүгийн системээс эдийн засагт орох мөнгийг Засгийн газар татаж, зээлийн эх үүсвэрийн хомсдол үүсгэх, зах зээлд хүү өсгөж, улмаар эдийн засгийн тэлэлтийг хязгаарлахаас зайлсхийх ач холбогдолтой, гуравдугаарт дотоодын бондыг эргээд төлөх эх үүсвэрээ бүрдүүлээгүй учраас төсвийнхөө хүрээнд шийдвэрлэж байна. Дотоодын бондын өрийн үлдэгдэл 3 дахин буурч, 2021 эхний хагас жилийн байдлаар 1,046.1 тэрбум төгрөг болжээ.

Цаашид дотоодын бондыг эдийн засгийн өсөлтийг хангах, төсөвт үр ашгаа өгөх төслүүдийг санхүүжүүлэхэд зориулан гаргах нь чухал байна. Юуны өмнө Төсвийн тогтвортой байдлын хуульд зааснаар төмөр зам, цахилгаан станц, газрын тос, олон улсын стандартыг хангах экспортын үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай болно. Зээлийн хүүний зөрүүгийн санхүүжилтэд зориулан 2022 оны төсөвт тусгасан 210 тэрбум төгрөгөөс наад зах нь 50 хувийг томоохон төслүүдээ урагшлуулахад дэмжлэг үзүүлэхийг санал болгож байна.

Засгийн газрын бонд, түүний дотор дотоодын бонд гаргаж, төсвийн нийт алдагдлыг санхүүжүүлэх нь “төсвийг алдагдалтай байлгаж болдог” гэсэн буруу сэтгэлгээнээс үүсэлтэй байна.

Үүнээс гадна өрийн үлдэгдлийг өнөөгийн үнэ цэнээр тооцох, хоёр өөр үнэлгээтэй үзүүлэлтүүдийг харьцуулах нь эдийн засгийн утга, агуулга муутайн дээр америк доллар, еврогийн хүү нэг хувиас доош орсон учир шинжээчид нэрлэсэн үнэлгээтэй тоо баримтыг судалгаанд хэрэглэдэг болжээ. Иймд үүнтэй холбоотой хуулийн заалтыг өөрчлөх хэрэгтэй гэсэн саналтай байгаа болно.

**Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд дараах саналуудыг тусгуулахаар санал болгож байна. Үүнд:**

- 1) Дэлхий зах зээлийн эрсдэлийг сайтар тооцож, төсвийн орлого, зарлагыг тус бүрд нь 500 тэрбум төгрөгөөс доошгүйгээр бууруулах. Тухайлбал, Ногдол ашгаар төсөвт төвлөрөх 404.5 тэрбум төгрөгийн үндэслэлийг зэс, молибдений уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн зэс хайлах үйлдвэр, нүүрс олборлолтын “Эрдэнэс Тавантолгой” компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүний үнэт цаас гаргаж зах зээлээс босгосон хөрөнгийн баталгаа зэрэгтэй холбож үзэх. Төсвийн тухай хуулийн 29.3.5 заалтын дагуу “шинээр эхлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн тухайн жилд төлөвлөх хэсэг нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилснаас багагүй байхаар тооцож тусгах” (өөрөөр хэлбэл шилжих хөрөнгө оруулалтыг аль болох бага байлгах зарчим мөрдөх) тухай заалтад нийцэхгүй байгаа 471.7 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 196 төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнөөс хасах;
- 2) Ашигт малтмалын нөөцийн төлбөрийг хүүхдийн хадгаламжаар дамжуулан хуримтлуулахыг дэмжих, үүний тулд АМНАТ-аас орон нутгийн санд төвлөрөх мөнгийг хассан дүнд багтаан хүүхдэд зориулах хуримтлал үүсгэх зарчим тогтоох. Хэр хэмжээний мөнгө цугларах нь ашигт малтмалын үнийн түвшингээс хамаарч байх болно. Цаашид сар бүр олгож буй 100.0 мянган төгрөгөөс давахыг үгүйсгэхгүй байна. Хүүхдийн мөнгийг хадгаламжийн дансанд шилжүүлж, энгийн хадгаламжийн адил хүүтэй байлгах. Системийн чанартайгаар аль банкиг сонгох нь иргэний эрх байх учраас төрийн аливаа оролцоог хязгаарлах;
- 3) Төсвийн алдагдлыг эх үүсвэр нь шийдэгдсэн гадаадын зээлийн хэмжээгээр хязгаарлах;
- 4) Төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөхдөө төсвийн урсгал зардлыг цаашид нэмэгдүүлэхгүй байх төсөл, арга хэмжээг нийт хөрөнгө оруулалтын 50 хувиас хэтрүүлэхгүйгээр төлөвлөх зарчим баримтлах;
- 5) Төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөхдөө төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх төсөл, арга хэмжээг төлөвлөх зарчим баримтлах, зарим хөрөнгө оруулалтыг эдийн засаг, төсөв, төлбөрийн тэнцэл, ажлын байрны хангалтад түргэн хугацаанд үр ашгаа өгөх төслүүдэд дахин хуваарилалт хийж, ирээдүйтэй, экспорт, үндэсний орлогод үлэмж нөлөөтэй төслүүдээс эрэмбэлэн шүүж 2022 оны төсөвт тусгах нь зүйтэй байна;
- 6) Төсвөөс олгох зээлийн хөнгөлөлтийн зөрүүг багасгах арга замыг олж тогтоох, эсвэл төмөр зам, эрчим хүч, газрын тос, экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төслүүдийн хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх. Энэ чиглэлээр бонд гаргах, эсвэл энэ чиглэлийн бондыг худалдан авах баталгаа гаргах, харин төсвийн алдагдлыг бондоор санхүүжүүлэхээс аль болох татгалзах;
- 7) Аж үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тухайлбал Хөдөө аж ахуйн салбарт жилд үйлдвэрлэж байгаа 10,000 тн ямааны ноолуурыг ээрсэн утас болгох үйлдвэрлэл бий болгох. Сүлжмэл, нэхмэл эдлэл экспортлох, 20-25 сая малын арьс боловсруулах тэргүүний технологи бий болгон ашиглах, жилд 5 саяаас доошгүй малын махыг боловсруулж экспортлох, 30 мянган тн хонины ноосоороо хивс, эсгий

гутал үйлдвэрлэх, эрчим хүчний салбарт Тавантолгойн цахилгаан станцын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, Зүүн хойд Азийн орнуудтай хамтран сэргээгдэх эрчим хүчний Азийн супер сүлжээнд холбогдож алсдаа эрчим хүч экспортлох, Хойд Хятадын бүс нутгийн эрчим хүчний дутагдлыг нөхөхөд СЭХ нийлүүлэх;

- 8) Төсвийн тусгай шалгуурыг өөрчилдөг явдлыг зогсоож, хуулийн дагуу 4 жил тутам сайжруулах чиглэлээр хянан үзэж байх;
- 9) Засгийн газрын өрийг өнөөгийн үнэ цэнээр тооцдог хуулийн заалтыг хүчингүй болгох;
- 10) Цар тахлын үед гадаад орчин хязгаарлагдах эрсдэлтэй учир төсвөөр санхүүжих дотоодын худалдан авалт, захиалгыг эрс нэмэгдүүлэх;
- 11) Орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр төсвийн орлого, татварын шинэчлэлтэй холбогдуулан төсвийн зарлагын шинэчлэл хийх. Төсөв хэмнэх, орлого олох хөшүүрэг бий болгож, нэмэгдэл хэмнэлт, орлогыг цахимжуулах, техник хэрэгслийг сайжруулах, өндөр ур чадвартай боловсон хүчин урьж ажиллуулахад ашиглах эрх олгох;
- 12) Орон нутгийн хөгжлийн сангаас ажлын байрны зээл олгох эрхийг нээх эрх зүйн тогтолцоо бүрдүүлэх;
- 13) Төсвийн аливаа дэмжлэг халамж, шилжүүлэг, хөнгөлөлтийг татварын бүртгэлтэй холбох нэгдсэн сүлжээ бий болгох;
- 14) Төсөв боловсруулахдаа Төсвийн хүрээний мэдэгдлийн тухай Улсын Их Хурлаас баталсан зорилтоо баримтлахгүй 4 сарын дараа өөрчлөх хуулийн төслийг Төсвийн хуулийн төсөлтэй хамт оруулж ирж өөрчлөн баталж, түүндээ нийцүүлэн төсвийн хуулиа батлуулдаг буруу арга барил Засгийн газрын үйл ажиллагаанд хэвшил болсон байгаад дүгнэлт хийж, зогсоох хэрэгтэй;
- 15) Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагын шалгуур үзүүлэлтийг өөрчлөн төсвийн төслөө боловсруулж байгаа буруу арга барилыг өөрчилж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шалгуур үзүүлэлтийг сэргээж, чанд мөрдөх нь зүйтэй.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд өгсөн саналыг төсвийн төслийг хэлэлцэх явцад анхаарч үзэж тусгана гэдэгт итгэлтэй байна.

## **ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ**



## ХАВСРАЛТУУД

### Хавсралт хүснэгт №1а: МОНГОЛ УЛСЫН ГАДААД НИЙТ ӨР (ангиллаар, оны эцэст)

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Сая ам.доллар	IV	IV	IV	IV	IV	IV	IV	IV	IV	IV	IV	II
Засгийн газар	1,882	2,043	3,599	3,535	3,501	3,760	4,869	7,321	7,184	7,806	8,654	8,447
Төвбанк	274	268	571	1,130	1,570	1,960	1,791	2,025	2,030	1,985	2,221	2,195
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	512	740	1,176	1,376	1,762	2,129	2,417	2,194	2,230	2,138	1,651	1,620
Бусад салбарууд	1,474	1,905	2,836	3,199	3,977	3,749	8,121	7,956	8,042	8,407	8,430	8,694
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	2,986	5,953	9,028	10,590	11,041	11,121	7,426	7,996	9,228	10,366	11,406	12,002
<b>Нийт</b>	<b>7,128</b>	<b>10,908</b>	<b>17,211</b>	<b>19,830</b>	<b>21,851</b>	<b>22,718</b>	<b>24,625</b>	<b>27,493</b>	<b>28,715</b>	<b>30,702</b>	<b>32,362</b>	<b>32,958</b>

### Хавсралт хүснэгт №1б: ХУВИЙН ХЭВШЛИЙН ГАДААД ӨР (оны эцэст, уул уурхай болон бусад)

/Тэрбум ам.доллар/	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Нийт гадаад өр</b>	<b>7,128</b>	<b>10,908</b>	<b>17,211</b>	<b>19,830</b>	<b>21,851</b>	<b>22,718</b>	<b>24,625</b>	<b>27,493</b>	<b>28,715</b>	<b>30,702</b>	<b>32,362</b>
Үүнээс Хувийн хэвшлийн гадаад өр	4,972.02	8,597.28	13,039.70	15,164.62	16,777.01	16,995.96	17,962.78	18,144.24	19,500.47	20,911.41	21,487.00
Үүнээс Уул уурхай, олборлолт	2,728.62	5,581.44	8,308.23	10,125.37	10,290.00	9,681.02	10,505.37	11,602.42	12,802.71	13,729.69	14,930.50
Үлдэх нь	2,155.98	2,310.72	4,171.30	4,665.38	5,073.99	5,722.04	6,662.22	9,348.76	9,214.53	9,790.59	10,875.00

### Хавсралт хүснэгт №1с: МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД БОНДЫН ӨР (бондны төрлөөр, оны үлдэгдлээр)

2021.09.30-ны өдрийн байдлаар

Салбар	Үнэг цаас гаргагч	Гаргасан огноо	Хугацаа	Валютын төрөл	Хэмжээ	Хүү	Жилийн хүү	Дуусах огноо	Үлдэгдэл дүн
Засгийн газар	Чингис /Mongol 2022/	2012.12.05	10 жил	USD	1,000 сая \$	5.13%	-	2022.12.05	-
	Мазаалай	2016.04.06	5 жил	USD	500 сая \$	10.88%	-	2021.04.06	-
	Хуралдай	2017.03.09	7 жил	USD	600 сая \$	8.75%	52.5 сая \$	2024.03.09	600 сая \$
	Гэрэгэ	2017.10.25	5.5 жил	USD	800 сая \$	5.63%	45.0 сая \$	2023.05.01	599 сая \$
	Номад	2020.10.07	6 жил	USD	600 сая \$	5.13%	30.8 сая \$	2026.04.07	600 сая \$
	Century1	2021.07.07	6 жил	USD	500 сая \$	3.50%	17.5 сая \$	2027.07.07	500 сая \$
	Century2	2021.07.07	10 жил	USD	500 сая \$	4.45%	22.3 сая \$	2031.07.07	500 сая \$
Самурай	2018.10.25	10 жил	JPY	30 тэрбум иен	1.52%	456 сая иен	2023.12.25	30 тэрбум иен	

<b>Бусад сектор/ Хөгжлийн банк</b>	ХБ 2023	2018.10.23	5 жил	USD	500 сая \$	7.25%	36.2 сая \$	2023.10.23	500 сая \$
<b>Бусад сектор</b>	Энержи Ресурс 2024	2019.04.15	5 жил	USD	440 сая \$	9.25%	40.7 сая \$	2024.04.15	440 сая \$
	Анд систем	2018.10.29	3 жил	MNT	7 тэрбум ₮	6.00%	420 сая ₮	2021.10.29	7 тэрбум ₮
	МИК2022	2019.01.29	3 жил	USD	300 сая \$	9.75%	10.4 сая \$	2022.01.29	106.9 сая \$
	МИК2024	2021.02.08	3 жил	USD	250 сая \$	8.85%	22.1 сая \$	2024.02.08	250 сая \$
Нийт ам.долларын дүн					<b>4.49</b> тэрбум \$		<b>277.5 сая</b> \$		<b>4.09</b> тэрбум \$
Нийт Төгрөгийн дүн					<b>7 тэрбум ₮</b>		<b>420 сая ₮</b>		<b>7 тэрбум ₮</b>
Нийт Иенийн дүн					<b>30 тэрбум</b> иен		<b>456 сая</b> иен		<b>30 тэрбум</b> иен
НИЙТ ДҮНГ ТӨГРӨГӨӨР ИЛЭРХИЙЛБЭЛ					<b>13,564</b> тэрбум ₮		<b>802,7</b> тэрбум төгрөг		<b>12,424.3</b> тэрбум төгрөг

## Хавсралт хүснэгт №2: ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ (оноор)

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
<i>Сая ам.доллаар</i>	A	A	A	A	A	A	A	A	A	A	A	8
<b>I. УРСГАЛ ДАНС</b>	<b>-885</b>	<b>-</b> 4,512	<b>-5,381</b>	<b>-4,732</b>	<b>-1,934</b>	<b>-948</b>	<b>-700</b>	<b>-1,155</b>	<b>-2,207</b>	<b>-2,162</b>	<b>-675</b>	<b>-1,380</b>
<b>Кредит</b>	<b>3,733</b>	<b>5,050</b>	<b>5,020</b>	<b>4,886</b>	<b>6,468</b>	<b>5,517</b>	<b>5,978</b>	<b>7,141</b>	<b>8,461</b>	<b>9,184</b>	<b>8,358</b>	<b>5,773</b>
<b>Дебет</b>	<b>4,618</b>	<b>9,563</b>	<b>10,400</b>	<b>9,618</b>	<b>8,402</b>	<b>6,466</b>	<b>6,678</b>	<b>8,297</b>	<b>10,668</b>	<b>11,346</b>	<b>9,033</b>	<b>7,153</b>
<b>I.A Барaa ба үйлчилгээний худалдаа</b>	<b>-475</b>	<b>-</b> 3,517	<b>-4,456</b>	<b>-3,918</b>	<b>-1,111</b>	<b>-153</b>	<b>0</b>	<b>278</b>	<b>-1,303</b>	<b>-834</b>	<b>305</b>	<b>-317</b>
<b>Кредит</b>	<b>3,394</b>	<b>4,577</b>	<b>4,452</b>	<b>4,478</b>	<b>6,078</b>	<b>5,137</b>	<b>5,605</b>	<b>6,801</b>	<b>7,668</b>	<b>8,416</b>	<b>7,646</b>	<b>5,340</b>
<b>Дебет</b>	<b>3,869</b>	<b>8,094</b>	<b>8,908</b>	<b>8,396</b>	<b>7,189</b>	<b>5,290</b>	<b>5,605</b>	<b>6,523</b>	<b>8,971</b>	<b>9,249</b>	<b>7,340</b>	<b>5,656</b>
<b>I.A.a Барaa</b>	<b>-172</b>	<b>-</b> 2,669	<b>-3,030</b>	<b>-2,608</b>	<b>178</b>	<b>563</b>	<b>1,338</b>	<b>1,494</b>	<b>676</b>	<b>1,158</b>	<b>1,756</b>	<b>409</b>
<b>Кредит</b>	<b>2,908</b>	<b>4,056</b>	<b>3,800</b>	<b>3,789</b>	<b>5,471</b>	<b>4,446</b>	<b>4,804</b>	<b>5,834</b>	<b>6,557</b>	<b>7,183</b>	<b>6,991</b>	<b>4,869</b>
<b>Дебет</b>	<b>3,080</b>	<b>6,725</b>	<b>6,830</b>	<b>6,397</b>	<b>5,293</b>	<b>3,884</b>	<b>3,466</b>	<b>4,341</b>	<b>5,881</b>	<b>6,025</b>	<b>5,235</b>	<b>4,460</b>
<b>I.A.b Үйлчилгээ</b>	<b>-303</b>	<b>-848</b>	<b>-1,426</b>	<b>-1,310</b>	<b>-1,289</b>	<b>-715</b>	<b>-</b> 1,338	<b>-1,216</b>	<b>-1,978</b>	<b>-1,992</b>	<b>-</b> 1,450	<b>-726</b>
<b>Кредит</b>	<b>486</b>	<b>521</b>	<b>652</b>	<b>689</b>	<b>607</b>	<b>691</b>	<b>801</b>	<b>966</b>	<b>1,112</b>	<b>1,233</b>	<b>655</b>	<b>471</b>
<b>Дебет</b>	<b>789</b>	<b>1,369</b>	<b>2,077</b>	<b>1,999</b>	<b>1,896</b>	<b>1,406</b>	<b>2,139</b>	<b>2,182</b>	<b>3,090</b>	<b>3,224</b>	<b>2,105</b>	<b>1,196</b>
<b>I.B Анхдагч орлого</b>	<b>-598</b>	<b>-</b> 1,243	<b>-1,167</b>	<b>-963</b>	<b>-973</b>	<b>-970</b>	<b>-911</b>	<b>-1,613</b>	<b>-1,228</b>	<b>-1,569</b>	<b>-</b> 1,253	<b>-1,207</b>
<b>Кредит</b>	<b>30</b>	<b>43</b>	<b>61</b>	<b>52</b>	<b>57</b>	<b>59</b>	<b>68</b>	<b>76</b>	<b>346</b>	<b>394</b>	<b>341</b>	<b>230</b>
<b>Дебет</b>	<b>627</b>	<b>1,286</b>	<b>1,227</b>	<b>1,015</b>	<b>1,030</b>	<b>1,028</b>	<b>980</b>	<b>1,689</b>	<b>1,573</b>	<b>1,963</b>	<b>1,595</b>	<b>1,436</b>
<b>I.C Хоёрдогч орлого</b>	<b>187</b>	<b>248</b>	<b>242</b>	<b>149</b>	<b>150</b>	<b>174</b>	<b>212</b>	<b>180</b>	<b>324</b>	<b>241</b>	<b>273</b>	<b>144</b>
<b>Кредит</b>	<b>309</b>	<b>430</b>	<b>507</b>	<b>355</b>	<b>333</b>	<b>321</b>	<b>305</b>	<b>264</b>	<b>448</b>	<b>374</b>	<b>371</b>	<b>204</b>
<b>Дебит</b>	<b>122</b>	<b>182</b>	<b>265</b>	<b>207</b>	<b>183</b>	<b>147</b>	<b>93</b>	<b>85</b>	<b>124</b>	<b>134</b>	<b>98</b>	<b>60</b>

**Хавсралт хүснэгт №3: МОНГОЛ УЛСАД ОРСОН ГШХО-ЫН ҮЛДЭГДЭЛ  
(Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, оны үлдэгдлээр)**

Тэмдэглэл: Барилга, Боловсрол, Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, Мэдээлэл, холбоо, Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа, Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, Урлаг, үзвэр, тоглоом наадам, Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь салгаж тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ, Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа, Цахилгаан, хий, уур, агааржуулалт, Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал гэсэн салбар тус бүрийн дүнг үл харуулсан болно.

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Сая ам.доллар	IV	IV	IV	IV	IV	IV	IV	IV	IV	IV	IV	II
Боловсруулах үйлдвэрлэл	431.07	532.33	632.19	638.06	659.43	681.43	285.41	326.09	317.23	333.85	319.69	338.62
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	577.49	1034.98	1347.6	1083.71	1178.4	1383.46	1122.35	1525.14	1634.67	1788.67	1841.79	1883.08
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	232.43	365.99	532.69	595.4	675.12	720.35	733.97	793.56	919.05	1047.54	955.45	1023.54
Уул уурхай, олборлолт	5692.8	9626.14	13051.28	15109.47	15419.73	15360	11518.26	12825.83	14566.78	16366.07	17703.32	18602.39
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	388	436.95	502.73	508.49	552.68	593.46	599.55	650.76	676.26	699.34	993.89	1004.87
<b>Нийт</b>	<b>8444.69</b>	<b>13332.68</b>	<b>17668.37</b>	<b>19579.29</b>	<b>20247.03</b>	<b>20696.26</b>	<b>16277.49</b>	<b>18019.87</b>	<b>20223.02</b>	<b>22555.68</b>	<b>24206.69</b>	<b>25270.48</b>

**Хавсралт хүснэгт №4а: ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН  
(орлогын аргаар, оны үнээр)**

	2014	2015	2016	2017	2018	2019	2020
/тэрбум төгрөг/	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц
ДНБ-ний хэмжээ	22,227.05	22,894.78	23,931.34	28,010.71	32,582.63	37,839.23	37,453.28
Ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого	5,852.49	6,234.96	6,829.89	7,465.85	8,571.53	10,017.70	11,056.04
Үйлдвэрлэл, импортын татвар, цэвэр	2,189.57	1,979.03	2,128.84	2,654.95	3,658.86	4,164.06	3,701.56
Үндсэн хөрөнгийн хэрэглээ	1,707.55	2,958.26	3,364.57	3,658.76	3,671.78	4,122.29	4,534.97
Үйл ажиллагааны ашиг /холимог орлого, цэвэр	12,477.45	11,722.52	11,608.04	14,231.15	16,680.46	19,535.17	18,160.71

**Хавсралт хүснэгт №4b: ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН  
(орлогын аргаар, орлогын татвараар, оны үнээр)**

	2016		2017		2018		2019		2020	
/тэрбум төгрөг/	Гүйц		Гүйц		Гүйц		Гүйц		Гүйц	
ДНБ	23,931.3	(100.0%)	28,010.7	(100.0%)	32,582.6	(100.0%)	37,839.2	(100.0%)	37,453.3	(100.0%)
Ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого	6,829.9	(28.5%)	7,465.8	(26.7%)	8,571.5	(26.3%)	10,017.7	(26.5%)	11,056.0	(29.5%)
НДШ - 1	554.9		660.7		819.2		1,015.3		793.0	
ХХОАТ	566.2		695.1		856.1		932.8		864.4	
НИЙТ	1,121.1		1,355.8		1,675.2		1,948.0		1,657.4	
ЭЗЛЭХ ХУВЬ	16.41%		18.16%		19.54%		19.45%		14.99%	
Үйлдвэрлэл, импортын татвар, цэвэр	2,128.8	(8.9%)	2,654.9	(9.5%)	3,658.9	(11.2%)	4,164.1	(11.0%)	3,701.6	(9.9%)
Үндсэн хөрөнгийн хэрэглээ	3,364.6	(14.1%)	3,658.8	(13.1%)	3,671.8	(11.3%)	4,122.3	(10.9%)	4,535.0	(12.1%)
Үйл ажиллагааны ашиг /холимог орлого, цэвэр	11,608.0	(48.5%)	14,231.2	(50.8%)	16,680.5	(51.2%)	19,535.2	(51.6%)	18,160.7	(48.5%)
ААНОАТ	520.0		962.1		1,276.9		1,660.6		1,398.5	
АМНАТ	288.7		192.6		320.6		484.2		401.9	
НДШ - 2	554.9		660.7		819.2		1,015.3		793.0	
НИЙТ	1,363.6		1,815.5		2,416.7		3,160.0		2,593.4	
ЭЗЛЭХ ХУВЬ	11.75%		12.76%		14.49%		16.18%		14.28%	

**Хавсралт хүснэгт №5: МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ (2014 оноос 2022 он)**

	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
/тэрбум төгрөг/	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Тод	Төс
ДНБ-ний хэмжээ	22,227.10	22,894.80	23,931.30	28,010.70	32,582.60	37,839.20	37,453.30	42,133.50	46,805.50
Нийт Орлого Ба Тусламжийн Дүн	6,316.50	5,983.40	5,835.00	7,958.26	10,172.76	12,040.33	10,444.17	13,731.67	16,415.11
Төсвийн Тэнцвэржүүлсэн Орлого Ба Тусламжийн Дүн	6,276.60	5,981.06	5,835.00	7,274.86	9,345.08	10,905.51	9,463.84	12,056.44	15,771.72
Нийт Зарлага Ба Цэвэр Зээлийн Дүн (Тэнцвэржүүлсэн Орлогод Нийцүүлсэн)	7,144.60	7,137.97	9,495.30	9,017.32	9,317.22	11,661.70	13,904.27	15,748.28	18,158.80
Үндсэн Тэнцэл	-828	-1,154.56	-3,660.30	-1,059.05	855.54	378.63	-3,460.17	-2,016.61	-1,743.69
Төсвийн Тэнцэл (Тэнцвэржүүлсэн Орлогоор Тооцсон)	-867.9	-1,156.91	-3,660.30	-1,742.46	27.86	-756.19	-4,440.43	-3,691.84	-2,387.08

**Хавсралт хүснэгт №6: МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ ЭКСПОРТ  
(Нийт болон Гашуунсухайт, тоо хэмжээгээр, үнийн дүнгээр)**

Үзүүлэлт	2016		2017		2018		2019		2020	
Боомтын нэр	Тоо, сая.тонн	Үнийн дүн, сая.ам.доллар	Тоо, сая.тонн	Үнийн дүн, сая.ам.доллар	Тоо, сая.тонн	Үнийн дүн, сая.ам.доллар	Тоо, сая.тонн	Үнийн дүн, сая.ам.доллар	Тоо, сая.тонн	Үнийн дүн, сая.ам.доллар
<b>Нийт</b>	<b>25.71</b>	<b>971.76</b>	<b>32.99</b>	<b>2,256.65</b>	<b>35.79</b>	<b>2,788.57</b>	<b>36.47</b>	<b>3,074.38</b>	<b>28.59</b>	<b>2,123.67</b>
Гашуунсухайт	12.85	604.42	17.17	1,499.47	18.18	1,826.79	20.50	2,058.67	14.74	1,290.91

**Хавсралт хүснэгт №7: МОНГОЛ УЛСЫН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ИМПОРТ  
(тоон хэмжээгээр, үнийн дүнгээр)**

Үзүүлэлт	2016		2017		2018		2019		2020		2021 (I-IX)	
Барааны нэр	Тоо, сая.квтц	Үнийн дүн, сая.ам.доллар	Тоо, сая.квтц	Үнийн дүн, сая.ам.доллар	Тоо, сая.квтц	Үнийн дүн, сая.ам.доллар	Тоо, сая.квтц	Үнийн дүн, сая.ам.доллар	Тоо, сая.квтц	Үнийн дүн, сая.ам.доллар	Тоо, сая.квтц	Үнийн дүн, сая.ам.доллар
<b>Нийт</b>	<b>1,420.2</b>	<b>125.4</b>	<b>1,574.3</b>	<b>136.0</b>	<b>1,665.7</b>	<b>142.5</b>	<b>1,722.7</b>	<b>144.4</b>	<b>1,684.9</b>	<b>141.7</b>	<b>1,246.3</b>	<b>111.7</b>
БНХ АУ	1,117.9	104.3	1,216.3	110.4	1,261.9	114.7	1,342.1	116.6	1,391.8	120.6	1,001.5	92.7
ОХУ	302.3	21.0	358.0	25.6	403.8	27.8	380.6	27.8	293.1	21.1	244.7	19.1